

2023 он 12 сар 13 өдөр

Дугаар 4/23

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

### Залгамж халааны бодлого батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь хэсэг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 12 сарын 13-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн “Залгамж халааны бодлого”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах, гүйцэтгэлийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд тайлагнаж ажиллахыг Гүйцэтгэх Захирал (Г.Цогбадрах)-д, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитор (П.Бямбасүрэн)-г тус тус даалгасугай.

ДАРГА



О.ОДБАЯР

## АРД ДААТГАЛ ХК-ИЙН ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГО

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү Залгамж халааны бодлого (цаашид “Бодлого” гэх)-ын зорилго нь Ард даатгал ХК (цаашид “Компани” гэх)-ийн эрх бүхий болон түлхүүр албан тушаалтны залгамж халааг урьдчилан бэлтгэх, хөгжүүлэх, сургахад оршино.
- 1.2. Эрх бүхий болон түлхүүр албан тушаалтан гэдэгт Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд Эрх бүхий албан тушаалтнаар тусгагдаагүй боловч бизнесийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, компанийн алсын хараа, эрхэм зорилго, стратегийн хэрэгжилтэд чухал ач холбогдолтой албан тушаалтнуудыг хамруулан ойлгоно.
- 1.3. Компани нь мэргэжлийн өндөр ур чадвартай, хариуцлагатай, мэргэшсэн боловсон хүчний нийлүүлэлтийг хангахын тулд ажилтнуудын карьер хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, түлхүүр ажлын байранд тохирох хүний нөөцийг бэлтгэхийг зорино.
- 1.4. Компанийн Залгамж халааны бодлогын ач холбогдлыг компанийн бүх ажилтнуудад сурталчлан таниулахад гүйцэтгэх удирдлагын багийнхан чухал үүрэгтэй оролцоно.
- 1.5. Залгамж халааг хэрэгжүүлэхэд дараах зарчмуудыг баримтална.
  - 1.5.1. Залгамж халааг бэлтгэх, томилохдоо хүн бүрд адил, тэгш боломжийг олгон, тэгш хандана.
  - 1.5.2. Залгамжлагчдыг дотоод эх үүсвэрээс хангахыг зорино.
  - 1.5.3. Залгамж халааг мэргэшсэн, тогтвортой хүний нөөцөөр бүрдүүлэхийг зорино.
  - 1.5.4. Мэдээллийн ил тод байдлыг эрхэмлэн, оролцогч талуудыг үнэн зөв мэдээллээр хангана.

### Хоёр. Хэрэгжүүлэх үйл явц

- 2.1. Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн дэргэдэх Засаглал, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хороо (цаашид “Хороо” гэх) нь Компанийн эрх бүхий албан тушаалтан болон түлхүүр ажлын байранд нэр дэвшигчид тавигдах шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоож, шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгнө.
- 2.2. Хороо нь эрх бүхий болон түлхүүр албан тушаалтны залгамж халааг бэлтгэхийн тулд гаднаас болон компанийн хүний нөөцөөс ажлын байранд тохирох нэр дэвшигчдийг тодорхойлж, компанийн стратегийн төлөвлөгөө, хүний нөөцийн бодлого болон боловсон хүчний сургалт, хөгжлийн бодлоготой уялдуулан, шалгуурт нийцсэн нэр дэвшигчдийн сургалт, хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилтийг хангах, гүйцэтгэлийг үнэлэх замаар залгамж халааны бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.3. Өндөр насны тэтгэвэрт гарах, жирэмсний амралт авах гэх мэт таамаглаж болохуйц эрх бүхий болон түлхүүр ажлын байрны хэрэгцээг урьдчилан төлөвлөж, нэр дэвшигчдийг тодорхойлон, зохих ёсоор, шат дараалалтайгаар шилжилтийг хийхийн тулд Хороо болон гүйцэтгэх удирдлага жилд нэгээс доошгүй удаа судалгаа хийнэ.
- 2.4. Компани өөрийн хүний нөөцийн алба эрх бүхий болон түлхүүр албан тушаалтны хэрэгцээ, сонгогдсон нэр дэвшигчдийн ахиц, дэвшил болон бодлогын хэрэгжилтийг жилд нэгээс доошгүй удаа хороонд тайлагнах үүргийг хүлээх ба ерөнхий хэрэгжилтийг ТУЗ-д тайлагнана.
- 2.5. Компани нь ажлаас гарах, нас барах гэх мэт гэнэтийн болон гэнэтийн бус нөхцөл байдлаас

Ард даатгал ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны  
11 сарын 11 өдрийн 11/2 тоот тогтоолын хавсралт



үүдэх эрх бүхий болон түлхүүр ажлын байрны сул орон тоог нөхөх болзошгүй нөхцөл байдлын төлөвлөгөөтэй байж болно.

2.6. Гэнэтийн тохиолдолд авч хэрэгжрүүлэх арга хэмжээ.

2.6.1. Компанийн эрх бүхий албан тушаалтан болон түлхүүр ажилтан нас барах, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдах болон бусад урьдчилан тооцоолох боломжгүй гэнэтийн нөхцөл байдалд ТУЗ, Хороо, Гүйцэтгэх захирал, Хүний нөөцийн менежер яаралтай хуралдаж, тухайн эрх бүхий албан тушаалтан болон түлхүүр ажилтанг орлон ажиллах ажилтныг томилно.

2.7 ТУЗ-ийн гишүүдийн залгамж халаа.

2.7.1 ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, улираан томилох тохиолдолд Хороо нь сонгон шалгаруулалтыг нээлттэй, ил тод явуулж, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг бүртгэн урьдчилсан байдлаар үнэлж, холбогдох хуульд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд дүгнэлт гарган ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн, ХЭХ-д нэр дэвшүүлнэ.

2.7.2 ТУЗ-ийн гишүүн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас удаан хугацаагаар ажил үүргээ гүйцэтгэх боломжгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд компанийн дүрэмд заасны дагуу түүний залгамжлагчийг түр томилно.

2.8 Гүйцэтгэх захирлын залгамж халаа.

2.8.1 Гүйцэтгэх захирлын албан тушаалд шинээр болон улираан нэр дэвшүүлэх, чөлөөлөх нөхцөл байдал үүссэн тохиолдолд дотоод болон гадаад эх үүсвэрээс тохирох хүнийг сонгон шалгаруулж, нэр дэвшүүлэх санал гаргах бөгөөд ТУЗ-ийн хурлаар томилно.

2.9 Компанийн удирдлагын баг болон түлхүүр ажилтны залгамж халаа.

2.9.1 Компанийн удирдлагын баг болон түлхүүр ажилтны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, тэднийг чөлөөлөх, томилох нөхцөл байдал үүссэн тохиолдолд дотоод болон гадаад эх үүсвэрээс тохирох хүнийг Хүний нөөцийн менежер сонгон шалгаруулж, нэр дэвшүүлэх санал гаргаж, Гүйцэтгэх захирлын тушаалаар томилно.

### Гурав. Бусад

3.1. Хороо нь уг Бодлоготой уялдан гарах Компанийн дотоод журам, зааврыг хэлэлцэж, зөвлөмж гаргана.

3.2. Энэ баримт бичгийн хэрэгжилтэд Хороо хяналт тавьж ажиллах ба ТУЗ-өөс энэхүү бодлогын баримт бичгийн гүйцэтгэл, үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч, хэрэгжихүйц байлгах, сайжруулах зорилгоор нэмэлт, өөрчлөлт оруулах эрхийг эдэлнэ.

--ooOoo--